

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№23/581

ШУС, НУС

2022

**МОНЦАМЭ АГЕНТЛАГИЙН ЭХЭН ҮЕИЙН ТҮҮХЭНД ХОЛБОГДОХ
ЗАРИМ БАРИМТЫГ ТОДРУУЛАХ НЬ**

Ш.Батболд*

* МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн докторант

Түлхүүр үгс: Ардын хувьсгал, Хиагтыг чөлөөлсөн нь, Монголын цахилгаан мэдээний агентлаг, МОНТА, анхны мэдээ, Демкогийн дуртгал, “Власть Труда” сонин.

Аливаа улсын үндэсний мэдээллийн агентлаг бол тухайн улсынхаа талаарх үнэн бодит мэдээ мэдээллийг дотоодод төдийгүй гадаадад товхимол, сонин, сэтгүүл, радио, телевизээр, орчин үед интернэт-цахим сүлжээ, нийгмийн мэдээллийн хэрэгслээр хамгийн шуурхай түгээн дэлгэрүүлэх үүргийг гүйцэтгэдэг. Мөн үндэсний мэдээллийн агентлаг нь тухайн улсын албан ёсны мэдээллийн эх сурвалж хэмээн дотооддоо төдийгүй гадаад ертөнцөд хүлээн зөвшөөрөгдсөн байдаг билээ. Монгол Улсын хувьд дээрх шаардлагад нийцэж ажиллаж ирсэн байгууллага бол мэдээллийн МОНЦАМЭ агентлаг юм. Өөрөөр хэлбэл, Монгол Улсад энэ үүргийг МОНТА нэрээр анх үүссэн өнөөдрийн МОНЦАМЭ агентлаг 1921 оны 3 дугаар сарын 18-ны өдөр анхны мэдээгээ цацсан цагаас хойш 100 гаруй жилийн туршид гүйцэтгэж иржээ. Энэхүү илтгэлд Монголын үндэсний мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн эхэн үеийн түүхэнд хамаарах зарим мэдээллийг шинээр тодруулав.

1.И.Г.Демкогийн дурсамж: Баримт бичгүүд, судалгаа, үйл явдалд холбогдох хүмүүсийн бичсэн дуртгалаас харахад Ардын хувьсгалыг санаачлагчид Монгол Хиагт буюу Маймаа хотыг гамин цэргүүдээс чөлөөлж, анхны ялалтаа байгуулсан 1921 оны 3 дугаар сарын 18-нд түүнийгээ олон улсад мэдээлэх шаардлагатай болжээ. Үүнээс улбаалан Монгол Улсын анхны үндэсний мэдээллийн агентлаг МОНТА буюу өнөөдрийн МОНЦАМЭ үүсэж бий болжээ хэмээн үзэж бий болохоор байгаа юм. Өөрөөр хэлбэл, МОНЦАМЭ агентлаг бол орчин цагийн Монгол Улсыг тунхагласан Ардын хувьсгалыг олон улсад төдийгүй дотооддоо зарлан тунхаглах нийгмийн шаардлагаар үүсжээ.

Ардын хувьсгалыг үүсгэн байгуулагч Д.Сүхбаатар тэргүүтнүүд тэр үед Зөвлөлт Оросын талынхантай холбоотой болж, хоёр улсын хооронд байнга нууцаар зорчиж байсан байдаг. Энэ үедээ Оросын мэдээллийн РОСТА агентлаг (мөн Алс Дорнодын Бүгд Найрамдах Улсад ДАЛЪТА мэдээллийн агентлаг гэж байв)-аас санаа авч Монголд энэ агентлагийн хувилбарыг байгуулах талаар төлөвлөж, оросуудын тусламжийг авсан нь тодорхой бөгөөд чухамхүү ажил хэрэг болгосон өдөр нь анхныхаа томоохон ялалтыг байгуул-

сан 1921 оны гуравдугаар сарын 18-ны өдөр байв. Цахилгаан мэдээ дамжуулах газраа анх МОНТА хэмээн нэрлэсэн нь ч Орост РОСТА буюу Оросын цахилгаан мэдээний агентлаг гэж байсан тул Монголын цахилгаан мэдээний агентлаг-МОНТА (Монгольская Телеграфная Агенство) гэж оросоор шууд нэрлэсэн харагддаг. Үүнд, Монгол ардын журамт цэргүүдтэй хамтран ажиллаж, хувьсгалт өөрчлөлтийг удирдан чиглүүлж байсан тухайн үеийн Оросуудын шууд нөлөө, оролцоо өндөр үүрэгтэй байсан нь тодорхой. Энэ нь ч МОНТА-гийн анхны мэдээллийг бэлтгэсэн И.Г.Демкогийн дурдатгалаас тодорхой харагдаж байна. МОНТА-гийн анхны мэдээ орос хэлээр бичигдэж, Орос руу дамжуулагдсан нь ч тухайн үед Ардын хувьсгалыг удирдагчдын хамгийн итгэлт холбоотон, гадаад ертөнц рүү холбогдох цонх нь Зөвлөлт Орос Улс байсантай холбоотой юм.

МОНТА-гийн нэрээр 1921 оны 18-ны өдрийн Ардын хувьсгалын анхны ялалтын мэдээг РОСТА-гийн нэр дээр явуулсан хүн бол тухайн үеийн Монгол Ардын Намын Төв хорооны дэргэд уригдан ажиллаж байсан Коминтерны Алс Дорнодын нарийн бичгийн дарга нарын газрын төлөөлөгч С.С.Борисовын нарийн бичгийн дарга, Монгол ардын журамт цэргийн сурган боловсруулах тасагт зөвлөх-сургагчийн алба хааж байсан И.Г.Демко байв. Тэрбээр хожим 1967 онд Монгол Улсад зочлон ирэх үедээ МАХН-ын Төв хорооны дэргэдэх Намын түүхийн институтын хүсэлтээр дуртгалаа бичиж өгсөн бөгөөд уг дуртгалыг Д.Даш орчуулж, редакторлон 1981 онд “И.Г.Демко: Ардын хувьсгалын үйл хэргийн төлөө” нэрээр ном болгож гаргасан нь МОНЦАМЭ агентлагийн түүхийг тодруулахад чухал баримт болж үлджээ.

И.Г.Демко МОНТА-гийн анхны мэдээллийг хэрхэн бэлтгэсэн тухайгаа “...Түр амарсны дараа МОНТА-гийн нэрээр РОСТА агентлагийн нэр дээр илгээх цахилгаан мэдээний эхийг зохиох ажилд оров. Энэ нь Монгол ардын хувсгалын ялгуусан эхлэлтийн тухай мэдээ байсан юм...Решиковын байшинд ирж түр амарсны дараа би РОСТА агентлагийн нэр дээр явуулах хоёр цахилгаан мэдээний эхийг төлөвлөх ажилд оров. Эхний цахилгаан нь 1921 оны гуравдугаар сарын 18-нд Монгол ардын журамт цэрэг Маймаачин хотыг хятадын эзэмшлийн хүчний олон мянган цэргээс амжилттай чөлөөлсөн тухай, хоёр дахь нь Монгол ардын түр Засгийн газар байгуулагдсан тухай мэдээ байлаа...Тэгээд би Решиковын байшингаас ерөнхий консулын байшинд очиж Борисовтой уулзахаар явлаа. Миний бэлтгэсэн цахилгаан мэдээний эхийг С.С.Борисов үзээд зарим засвар хийв. Тухайлбал, “Монгольской Народно-революционной армией” гэсэн хэсгийг “самостоятельно образовавшейся Монгольской Народно-революционной армией” гэж засаж билээ. Эл мэдээний эх нооргийг бид бас Монгол ардын түр засгийн газрын хариуцлагатай нөхдөд үзүүлж, МОНТА-гийн нэрээр явуулахаар тохиролцсон билээ. Жич, МОНТА хэмээх Монголын цахилгаан мэдээний хороог 1921 оны тавдугаар сард албан ёсоор байгуулахын өмнө Ардын түр засгийн газрын албан мэдээг мөн тэрхүү нэрээр гадагш нэвтрүүлж байх шийдвэр гарч би бусад зарим нөхдийн хамт тэр үүргийг гүйцэтгэж байсан юм” (И.Г.Демко, Ардын хувьсгалын үйл хэргийн төлөө, 1981) хэмээн бичиж үлдээжээ.

Эндээс харахад Д.Сүхбаатар тэргүүтэй Ардын журамт цэргүүд Хиагтыг чөлөөлсөн орой “Мон-

гол Ардын журамт цэргүүд анхны ялалтаа байгууллаа”, “Монгол ардын түр засгийн газар байгуулагдлаа” гэсэн хоёр мэдээг МОНТА мэдээлэв хэмээн РОСТА-гийн нэр дээр явуулсан болж таарч байгаа юм. Харин “Правда” сонины 1921 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн дугаарын 4-р нүүрт “Восстание Монголов” (Монголчуудын бослого) нэрээр РОСТА-гаас эш татсан байдлаар мэдээлэгдсэн мэдээ нь Г.Демкогийн дээрх хоёр мэдээг нийлүүлсэн агуулгатай байна. Гурван өгүүлбэр тэрхүү мэдээний албан бус монгол орчуулга нь: **“МОНГОЛЧУУДЫН БОСЛОГО. ЧИТА. 1921 оны 3 дугаар сарын 23 /Дальта/. Троицкосавск /Дээд шивээ/ аас авсан мэдээнээс үзвэл Унгерн, Комаровский нарын удирдсан хэрмэл дээрэмчин бүлэг цагаантан хийгээд санаа сэтгэлээр бүрэн дампууран унасан хятадын цэргийн эрхтний аллага, таллагад нэрвэгдсэн монголчууд тэмцэн босож Маймаа /Хиагт/ суурин болон түүний ойролцоох газруудыг байлдан эзлээд Монгол ардын засгийн газрыг зарлан тунхаглав.**

Дэлхийн империалистуудын түрэмгий ашиг сонирхлыг илэрхийлсэн Оросын цагаантны балмад бодлогын эсрэг Монголын засгийн газар шийдвэртэй тэмцэж, тусгаар тогтнолоо хамгаалан нутаг дэвсгэртээ аж төрөн суугаа энгийн номхон орос, хятад, монгол иргэдийн энх амгалан байдлыг аль болохоор хамгаалах зорилт тавьж байна. Маймаа /Хиагт/-д гарсан улаан монголчуудын бослого нь монголын хүн амын бүх давхаргыг хамарч ойролцоох хошуудад амжилттай дэлгэрч байна гэж хилийн районоос мэдээллээ РОСТА” (Правда, 1921) юм.

МОНТА-гийн анхны мэдээг хэрхэн дамжуулсан талаараа И.Г.Демко “Монгол ардын журамт цэргийн дуртга-

лууд” номд өгсөн дурсамждаа бас товч дурдсан байна. Гэхдээ энэхүү дурсамж үндсэндээ өмнө дурдсантайгаа адил бөгөөд “Би албан үүргийнхээ зэрэгцээ Коминтерны төлөөлөгч С.С.Борисовын нарийн бичгийн даргын албыг хавсран гүйцэтгэж байлаа. Түүний даалгавраар миний бие Ардын түр засгийн газар байгуулагдсан тухай анхны мэдээг РОСТА агентлагийн нэр дээр дамжуулсан нь асар удалгүй “Правда” сонинд нийтлэгдсэн байв” (Дуртгал, 1982) гэсэн нь тус номыг эмхэтгэгчид түүний 1981 онд хэвлэгдсэн дуртгалын номоос товчлон нийтэлжээ гэж үзэж болохоор байна.

И.Г.Демког 1967 онд Монгол Улсад ирэхэд түүнтэй уулзаж, МОНТА буюу МОНЦАМЭ агентлаг хэрхэн байгуулагдсан тухай болон тухайн үед хийж гүйцэтгэж байсан ажил төрлийнх нь талаар яриулсан хүн бол МОНЦАМЭ агентлагийн ахмад ажилтан, сэтгүүлч, орчуулагч, МУСГЗ Г.Адъяа юм. Энэ тухай түүний дурсамжид “1967 оны хаврын нэгэн өдөр надад нэгэн завшаантай явдал тохиолдсон юм. Юу гэвэл түүхийн амьд гэрч, МОНЦАМЭ-гийн анхны эрхлэгч Иван Григорьевич Демко гэдэг хүн манай агентлаг дээр ирж надтай уулзаж маш сонирхолтой зүйл ярьсан билээ. Тэгэхэд би хэлтсийн дарга байлаа. 67 настай тэр хүний ой ухаан саруул гэж хачин. 1921 оны хувьсгалт үйл явдлуудыг яг л өчигдөрхөн болсон юм шиг, нүдэнд харагдтал дурсан ярьж байлаа. Тухайн үедээ улаан армийн улс төрийн ажилтан байсан тэр хүний ярьснаар бол 1921 оны гуравдугаар сарын 18-нд жанжин Сүхбаатар түүнийг дуудаж хэлэхдээ, манай өнөөдрийн энэ ялалтын тухай дэлхий дахин мэдэх ёстой. Ийм учраас Монголын цахилгаан мэдээний хороог байгуулж, даргаар нь

таныг томилж байна. Цахилгаан мэдээний хороог монголоор Монголын цахилгаан мэдээ буюу товчилсноор МОНЦАМЭ гэж нэрлэе. Оросоор МОНТА гэж нэрлэнэ биз гэсэн гэж И.Г.Демко ярьсан юм” (Г.Адъяа, 2021) хэмээжээ. И.Г.Демкогийн дурсамжид ч энэхүү уулзалтыг баталж “МОНЦАМЭ агентлагийн хэлтсийн дарга Г.Адъяа гэдэг их боловсролтой, орос хэл тун сайн мэддэг нэг залуу надтай уулзаж МОНТА агентлаг хэрхэн байгуулагдсан, түүний ажил төрлийн талаар надаар яриулж соронзон хальсанд тэрхүү яриаг буулган авч байв” (И.Г.Демко, Ардын хувьсгалын үйл хэргийн төлөө, 1981) гэсэн байна.

Гэхдээ энд МОНТА-гийн анхны мэдээг хэний даалгавраар дамжуулсан бэ гэдэгт И.Г.Демко зөрүүтэй дурссан байгаа юм. Тэр өөрийнхөө дуртгалд С.С.Борисовын даалгавраар мэдээ бэлтгэсэн гэж байгаа бол Г.Адъяад ярихдаа жанжин Д.Сүхбаатарын даалгаврыг биелүүлсэн гэжээ. Энэ нь тухайн цаг үеийнхээ хандлага, өнгө аясад тааруулж ярьсан хэрэг байж ч болох юм гэж үзэж байна.

И.Г.Демко МОНТА-гийн анхны мэдээг дамжуулсан төдийгүй бас анхны эрхлэгчээр нь хавсран ажиллаж байсан хүн юм. Тэрбээр 1921 оны зургаадугаар сарын дунд үе хүртэл МОНТА-гийн нэрээр РОСТА зэрэг оросын хэвлэл мэдээллийн хэрэгслүүд руу мэдээ дамжуулсан нь дуртгалд тодорхой байна.

Тухайлбал, “...Тэр өдөр (1921 оны зургаадугаар сарын 6) Борисов Троицкосавскийн районд дайсныг ялсан тухай цахилгаан мэдээ бэлтгээд МОНТА-гийн нэрээр РОСТА агентлагт уламжлахыг над даатгаж өөрөө миний оронд хянах байрнаа үлдэв...

...Зургаадугаар сарын 17-18-ны үед МАН-ын Төв хорооны урилгаар Коминтернийн Алс Дорнодын нарийн бичгийн дарга нарын газрын томилолтоор цэргийн ба штабын ажилтны хоёр дахь хэсэг хүрэлцэн ирэв. Тэдний дотроос Василий Людвигович Букатый цэргийн зөвлөлийн гишүүнээр, түүний гэргий Зинаида Николаевна Шахматова миний оронд МОНТА-гийн албанаа тус тус томилогдсон юм” (И.Г.Демко, Ардын хувьсгалын үйл хэргийн төлөө, 1981) гэх зэргээр бичжээ. Эндээс МОНТА-гийн эхэн үеийн түүхэнд холбогдох бас нэгэн орос хүн З.Н.Шахматова гэгч байжээ гэдэг нь ч харагдаж байна. Гэхдээ одоогоор энэ хүний талаар тодорхой мэдээлэл алга байгаа бөгөөд цаашид судалж тодруулах шаардлагатай юм.

2.“Власть Труда” сонинд гарсан МОНТА-гийн мэдээнүүд: Дээр дурдсанчлан И.Г.Демко энэ хугацаанд МОНТА-гийн нэрээр гадагш мэдээ нэвтрүүлэх үүргийг зарим нөхдийн хамт хийдэг байсан тухайгаа бичсэн. Ийм баримтууд эхнээсээ олдож байна. Тухайлбал, Эрхүү мужийн “Власть Труда” сонины 1921 оны дөрөвдүгээр сарын 26-ны өдрийн дугаарын 1-р нүүрт “Улаан ба цагаан Монгол” гэсэн товч тоймыг “МОНТА-гийн мэдээ” хэмээсэн тодотголтой нийтэлсэн байгаа бол түүнээс хоёр хоногийн дараах 28-ны өдрийн дугаарынхаа 1-р нүүрт “Монгол оронд” (В МОНГОЛИИ) гарчиг дор “МОНТА байгуулагдлаа”, “Хятадын эсрэг босохыг уриалсан Хутагтын уриалга”, “Улаан монголчуудын тулган шаардах бичиг” гэсэн 3 мэдээг МОНТА-г эх сурвалж болгон нийтэлжээ (Власть Труда, 1921).

Мөн 1921 оны долоодугаар сарын 13-ны өдөр мөнөөх Оросын Эрхүү хотноо гарч байсан “Власть Труда” сонинд “Чухал мэдээ” (Важнейшие

известия) гарчиг дор МОНТА-гийн нэрээр "Монголчууд чөлөөлөгчдөө ёслол төгөлдөр угтлаа", "Монголын шинэ засгийн газар", "Цагаантны дээрэмчдийг баривчиллаа" гэсэн дахиад гурван мэдээ гарсан нь одоогоор бидэнд олдоод байна. "Монголчууд чөлөөлөгчдөө ёслол төгөлдөр угтлаа" мэдээнд "Хутагтын Өргөөг эзлэн авахын угтал болгож хотын зээлийн газар, гудамж талбайд Зөвлөлтийн цэрэг болон Монголын улаан арми иргэдэд ямар ч хор хүргэхгүй, анд нөхдийн журмаар орж ирж буй хэмээн ухуулах хуудсаар дамжуулан сурталчилжээ. Ардын хувьсгалт засгийн газар болон улаан армийг Өргөөгөөс 10 гаруй км-ийн зайд хутагтын торгон цэргийн захирагч бараа бологчдын хамт угтан авчээ. Хотод орж ирэхэд баярын хувцсаа өмссөн морьтой хүмүүс хөлхөлдөж, Өргөө тэр чигээрээ баяр ёслолын байдалтай угтав. Хутагт ч ардын хувьсгалт засаг болон улаан армийнханд улаан хадаг өргөжээ. (Монта)" гэсэн байгаа бол "Монголын шинэ засгийн газар" мэдээнд "1921 оны 7 сарын 10. Монголын хуучин засгийн газраас засгийн эрхийг шинэ засгийн газарт шилжүүлэн өгөх ёслол Өргөөд болов. Ардын хувьсгалт засгийн газрын ерөнхий сайд бөгөөд Гадаад яамны

сайдаар Бодоо, Дотоод явдлын яамны сайдаар Да лам Пунцагдорж, Сангийн яамны сайдаар Данзан, Цэргийн яамны сайдаар Сүхбаатар, Шүүх яамны сайдаар бэйл Магсаржав нар томилогдов (Монта)" гэжээ.

Эндээс харахад тухайн үеийн РОСТА, "Правда" сонин болон Эрхүү, Чита зэрэг бүс нутгийн хэмжээнд гарч байсан хэвлэлүүдийн архивыг дахин сайн шүүж үзвэл МОНТА-гийн эхэн үед нэвтрүүлсэн мэдээнүүдийн тоо нэмэгдэх магадлалтай байна. Одоогоор бидэнд олдоод буй "Власть Труда" сонины 1921 оны зарим дугаарыг шүүж үзэхэд л 1921 оны гуравдугаар сард Монголд өрнөсөн үйл явдлаас эхлээд тус сонин тогтмол Монголын талаар мэдээлсэн байгаа бөгөөд эхэн үеийн мэдээнүүд нь РОСТА, ДАЛЬТА гэсэн эх сурвалжтай байснаа дөрөвдүгээр сарын сүүлээс МОНТА гол эх сурвалж болсон нь харагдаж байна.

«

Эндээс харахад тухайн үеийн РОСТА, "Правда" сонин болон Эрхүү, Чита зэрэг бүс нутгийн хэмжээнд гарч байсан хэвлэлүүдийн архивыг дахин сайн шүүж үзвэл МОНТА-гийн эхэн үед нэвтрүүлсэн мэдээнүүдийн тоо нэмэгдэх магадлалтай байна. Одоогоор бидэнд олдоод буй "Власть Труда" сонины 1921 оны зарим дугаарыг шүүж үзэхэд л 1921 оны гуравдугаар сард Монголд өрнөсөн үйл явдлаас эхлээд тус сонин тогтмол Монголын талаар мэдээлсэн байгаа бөгөөд эхэн үеийн мэдээнүүд нь РОСТА, ДАЛЬТА гэсэн эх сурвалжтай байснаа дөрөвдүгээр сарын сүүлээс МОНТА гол эх сурвалж болсон нь харагдаж байна

»

харагдаж байна.

Дүгнэлт: 1921 оны Ардын хувьсгалын үйл хэрэгт биечлэн оролцсон, Зөвлөлт Оросын иргэн И.Г.Демкогийн бичиж үлдээсэн дуртгал нь МОНТА (МОНЦАМЭ)-гийн эхэн үеийн түүхийг шинээр тодруулж, бататгах, тэр ч байтугай Хиагтыг чөлөөлсөн тухайн цаг үеийн бодит байдал, хүмүүс



Зураг 3. “Монта” эх сурвалжтай мэдээллүүд гарсан Эрхүүгийн “Власть Труда” сонины 1921 оны дөрөвдүгээр сарын 26, 28, долоодугаар сарын 13-ны өдрийн дугаарууд.

Эшлэл

1. Адъяа Г. МОНЦАМЭ бол Монголоо дэлхийд, дэлхийг Монголдоо таниулж, хүн ардаа соён гийгүүлж ирсэн ариун номын ордон. (Монголд үндэсний

мэдээллийн агентлаг үүсэж хөгжсөн нь: Дэлхийн мэдээллийн агентлагуудын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага. МОНЦАМЭ агентлагийн 100 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл). 2021. х.130.

2. “Власть Труда” сонин. 1921-04-26-ны өдрийн 435 (311) дугаар. х.1.
3. “Власть Труда” сонин. 1921-04-28-ны өдрийн 437 (313) дугаар. х.1.
4. “Власть Труда” сонин. 1921-07-13-ны өдрийн 497 (373) дугаар. х.1.
5. Демко И.Г. Ардын хувьсгалын үйл хэргийн төлөө (Дуртгал). 1981. Х.48, 49, 50, 81, 82, 83, 158.
6. Монгол ардын журамт цэргийн дуртгалууд. 1982. х.690.
7. “Правда” сонин. 1921-03-30-ны өдрийн дугаар. х.4.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Баасансүрэн Т. 2009. 1921 оны Ардын хувьсгал ба Монголын хэвлэлийн хөгжил. Дэд дэвтэр. УБ.
2. “Власть Труда” сонин. 1921-04-26-ны өдрийн 435 (311) дугаар. Эрхүү.
3. “Власть Труда” сонин. 1921-04-28-ны өдрийн 437 (313) дугаар. Эрхүү.
4. “Власть Труда” сонин. 1921-07-13-ны өдрийн 497 (373) дугаар. Эрхүү.
5. Дэлэг Г. 1965. Монголын тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ.
6. Демко И.Г. 1981. Ардын хувьсгалын үйл хэргийн төлөө (Дуртгал). УБ.
7. Монгол ардын журамт цэргийн дуртгалууд. 1982. УБ.
8. Монголд үндэсний мэдээллийн агентлаг үүсэж хөгжсөн нь: Дэлхийн мэдээллийн агентлагуудын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага. (МОНЦАМЭ агентлагийн 100 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл). 2021. УБ.
9. Мэдээллийн агентлагийн нийгэмд гүйцэтгэх үүрэг, хөгжлийн чиг хандлага. (МОНЦАМЭ агентлагийн 100 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл). 2016. УБ.

10. “Правда” сонин. 1921-03-30-ны өдрийн дугаар. Москва.

Summary

The National news agency of any country performs the function of operatively disseminating reliable information and news about its country both within the country and abroad through brochures, newspapers, magazines, radio, television, electronic social networks and public media. Also, the National news agency is considered and recognized as the official source of information of the given country both within the country and abroad.

The organization, whose activities meet the above requirements, in Mongolia is the MONTSAME news agency. In other words, in Mongolia, this function has been performed by the MONTA agency or today's MONTSAME news agency for more than 100 years since March 18, 1921, when it published its first news. This report contains new clarifications of some information regarding the history of the Mongolian National News Agency MONTSAME at the beginning period of its activity.